



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/168

Булгаг сум

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны мн/148 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2026 оны мн/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн жинхэнэ албаны 2026 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд явуулсугай.

2.2026 оны нэгдүгээр ээлжийн Цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Цэрэг татлагын товчооны дарга:	Д.Эрдэнэжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Орлогч дарга: хурандаа Гишүүд:	Д.Төмөрбаатар	(Цэргийн штабын дарга)
	Г.Цэдэв	(Цэргийн штабын офицер)
	Д.Бүрэнбаатар	(Цагдаагийн газрын дарга)
	О.Баатарчулуун	(Эрүүл мэндийн газрын дарга)
	Ш.Мэндсайхан	(Нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэх захирал)
Нарийн бичгийн дарга:	Ж.Уранчимэг	(Биеийн тамир, спортын газрын дарга)
	Г.Баасанцог	Сумдын Засаг дарга нар (Цэргийн штабын офицер)

3.Цэрэг татлагын товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг нэгдүгээр, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, сумдын цэрэг татлагаар орох хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Сум орон нутагтаа цэрэг татлагын ажлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулан цэрэг татлагын байрыг бэлдэх, 18-26 насны цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт бүрэн хамруулж, Засгийн газрын 2026 оны 09 дүгээр тогтоолын дагуу цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн албыг мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол хангасан иргэдийг цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд бэлэн

байлгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Засгийн газрын 2024 оны 140 дүгээр тогтоол "Иргэнийг цэргийн албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын 2 дугаар хэсгийн 2.2.1 дэх заалтад заасны дагуу цэргийн албанд татагдаж байгаа иргэдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, эрүүл мэндийн үзлэгт сумдын Анхан шатны эрүүл мэндийн төвийн шаардлагатай эмч, сувилагч нарыг байлцуулах, 2025 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын товчоогоор эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх талаар авсан арга хэмжээг илтгэх хуудсаар танилцуулах, эрүүл мэндийн үзлэгийн үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг сахиж ажиллах, цэргийн албанд татагдагчийн нэрсийг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулах, 18 нас хүрээгүй иргэдийг цэргийн албанд татахгүй байхыг сумдын Засаг дарга, сумын Анхан шатны эрүүл мэндийн төвийн дарга нарт, цэрэг татлагын товчоонд нарийн мэргэжлийн эмч нарыг томилон ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун), Нэгдсэн эмнэлгийн захирал (Ш.Мэндсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

6.Цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, зарлан дуудах мэдэгдэл аваад тогтоосон хугацаанд заасан байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг цэрэг татлагын байранд ирүүлэх ажлыг сумын хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан зохион байгуулж, цэрэг татлагын үед архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар)-т даалгасугай.

7.Гэмт хэргийн холбогдлоор шалгагдаж байгаа болон мансууруулах бодисын хамааралтай энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлөх бодис тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг, мансуурах донтой болох нь тогтоогдсон иргэдийн судалгааг гаргах, цэргийн албанд тэнцсэн иргэдийг тээвэрлэх явцад хяналт тавих, техникийн бэлэн байдлыг хангуулан ажиллахыг цэрэг татлагын товчоо (Д.Эрдэнэжаргал), сумдын Засаг дарга, аймгийн Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

8.Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг цэрэг татлага, сургалтын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

9.Цэргийн жинхэнэ албаны 2026 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага явуулсан дүн мэдээ, цэргийн албанд татагдагчийн анкетыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газарт тус тус хүргэж ажиллахыг Цэргийн штаб (Д.Төмөрбаатар)-т, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг цэрэг татлагын товчоо (Д.Эрдэнэжаргал)-нд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
дугаар сарын 27-ны өдрийн 108 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

1.Цэрэг татлагын товчооны дарга: Д.Эрдэнэжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

а.Цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангуулж, цэрэг татлагын ажиллагааг удирдах;

б.Товчооны гишүүдийг зохих үүргээр ханган, гишүүд үүргээ шударгаар биелүүлж байгаад хяналт тавих;

в.Товчооны гишүүдэд шаардагдах байр, хоол, томилолт, унааны зардлыг шийдвэрлэж өгөх;

г.Цэргийн албанд тэнцэгчдийг жинхэнэ алба хаалгах шийдвэр гаргаж, цэргийн анги салбарт хуваарилах ажилд хяналт тавих;

д.Цэрэг татлагын ажлын дүнг аймгийн Засаг даргад танилцуулах;

2.Орлогч дарга: Хурандаа Д.Төмөрбаатар (Цэргийн штабын дарга)

а.Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах;

б.Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх;

в.Хугацаат цэргийн албан хаагчдыг хуваарилагдсан анги салбарт нь хүргэж өгөх;

3.Нарийн бичгийн дарга: дэд хурандаа Г.Баасанцог (Цэргийн штабын офицер)

а.Цэрэг татлагын ажлын урьдчилсан бэлтгэлийг хангах;

б.Цэрэгт татагдагчдын баримт бичгийг бүрдүүлэх, баримт бичигт бичилт хийх;

в.Зэвсэгт хүчний Жанжин штабт явуулах мэдээ тайланг гаргаж хүргэх;

г.Цэрэг татлагын ажлын урьдчилсан бэлтгэлийг хангах;

д.Цэрэг татлагын товчооны дотоод хэв журмыг хангах;

4.Гишүүн: Хурандаа Д.Бүрэнбаатар (аймгийн Цагдаагийн газрын дарга)

а.Цэрэг татлагын үед цэрэг татлагын байранд цагдаагийн жижүүр гарган ажиллуулах, хяналт тавих;

б.Дэлгүүр, олон нийтийн үйлчилгээний газруудад согтууруулах ундааны зүйл худалдаалалтад хяналт тавих;

в.Цэрэг халах, үдэн гарах үед хэв журам сахиулах хүч нэмэгдүүлсэн эргүүл гарган ажиллуулах;

5.Гишүүн. О.Баатарчулуун (Эрүүл мэндийн газрын дарга)

а.Сумдын эрүүл мэндийн төвүүдэд цэргийн жинхэнэ албанд татагдаж байгаа иргэдэд Засгийн газрын 2024 оны 140 тогтоолын дагуу үзлэг шинжилгээ хийх боломж нөхцөлийг хангуулах;

б. Гишүүн: Ш.Мэндсайхан (аймгийн Нэгдсэн эмнэлгийн захирал)

а.Цэрэг татлагын товчооны эмч нарыг томилж, удирдан чиглүүлж зааварчилгаа өгөх, Засгийн газрын 2024 оны 140 тогтоол, иргэнийг цэргийн

жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журмыг мөрдлөг болгон ажиллах;

7.Гишүүн: Ж.Уранчимэг (Биеийн тамир, спортын газрын дарга)

а.Цэрэг татлагын байрыг бэлтгэж ажиллах нөхцөлөөр хангах;

8.Гишүүн: Г.Цэдэв (Цэргийн штабын офицерууд)

а. Цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангах, цэрэг татлагын байрын дэг журмыг сахиулах;

б. Цэрэг угтан авах, үдэн гаргах ажлыг зохион байгуулах;

_ оОо _

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн 1/03 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ ЭМЧ
НАРЫН НЭРС

№	Нэр	Ямар мэргэжлийн үзлэг явуулах
1	О.Бат-Эрдэнэ	Ерөнхий эмч
2	Г.Алзахгүй	Гэмтэл, мэс заслын эмч
3	Н.Цэрэнлхам	Сэтгэц, мэдрэлийн эмч
4	Б.Буянхишиг	Чих хамар хоолойн эмч
5	П.Булгамаа	БЗДХ, Арьс харшил
6	Д.Оюунтамир	Дотрын эмч
7	Т.Хаш-Эрдэнэ	Нүдний эмч
8	Г.Буянхишигт	Сүрьеэгийн эмч
9	А.Наранбаяр	Техникч
10	С.Жамбалдорж	Дүрс оношилгоо
11	П.Сугармаа	Шүдний эмч
12	Л.Чулуунхишиг	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

_ оОо _

Аймгийн Засаг даргын 2026 оны
03. дугаар сарын 27-ны өдрийн /2026/ дүгээр
захирамжийн гуравдугаар хавсралт

СУМДЫН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООГООР
ОРОХ ХУВААРЬ

№	Сумдын нэрс	Хяналтын тоо	Орох он сар өдөр	Орох цаг
1	Есөнбулаг	18-26 насны II зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг бүрэн хамруулах /ХАӨМСантай тулгаж гаргах	2026.04.17	09.00-14.30
2	Дэлгэр		2026.04.19	09.00-14.30
3	Чандмана			15.30-18.30
4	Эрдэнэ		2026.04.20	09.00-14.30
5	Бигэр			15.30-18.30
6	Халиун		2026.04.21	09.00-14.30
7	Цээл			15.30-18.30
8	Цогт		2026.04.22	14.00-17.30
			2026.04.23	Алтай явах
9	Алтай		2026.04.24	09.00-14.30
10	Бугат			16.30-20.00
11	Төгрөг		2026.04.25	09.00-14.30
12	Шарга			15.30-18.30
13	Тонхил		2026.04.26	09.00-14.30
14	Дарив			15.30-18.30
15	Хөхморьт		2026.04.27	09.00-14.30
16	Баян-Уул			15.30-18.30
17	Жаргалан		2026.04.28	09.00-14.30
18	Тайшир		15.30-18.30	

- Жич: 1. Сумын эмнэлэг бие бялдар үзэх жин, эхо аппарат бэлдэх
2. Сумдын Эрүүл мэндийн төвүүд урьдчилсан шинжилгээ дутуу хийгдэг дутагдал гардаг тул дахин ийм дутагдал гаргахгүй байх.
3. Цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийг цэрэг татлагын байранд байлгах

_ оОо _